

**НИЙСЛЭЛИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТЭС**

ИЛТГЭХ ХУУДАС

Сэтгэл ханамжийн судалгааны дүнгийн тухай

2020.05.20

Улаанбаатар хот

Нийслэлийн нийтлэг үйлчилгээний газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх, хэрэглэгчдийн санал хүсэлтийг нээлттэйгээр хүлээн авч, хурдан шуурхай шийдвэрлэх зорилгоор нийслэлийн засаг захиргааны байрууд, нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн салбаруудад үйл ажиллагаа явуулж байгаа нутгийн захиргааны байгууллагын албан хаагчдыг хамруулж, сэтгэл ханамжийн судалгааг цахим хэлбэрээр зохион байгууллаа.


Нэгтгэсэн хүснэгт

Хүснэгт 1


Асуултууд	НЗЗ-ны байр, НҮНТ-ийн салбарууд									Нийлбэр	Хувь
	1-р байр	2-р байр	3-р байр	4-р байр	5-р байр "Б"	5-р байр "В"	НҮНТ-ийн Мишээл салбар	НҮНТ-ийн Дунжингарав салбар	НҮНТ-ийн Драгон салбар		
Цэвэрлэгээ, үйлчилгээний чиглэлээр											
1. Таны ажиллаж буй өрөө, тасалгааны цэвэрлэгээ, үйлчилгээ хангалттай явагдаж байгаа эсэх?											
Сайн	49	108	88	46	12	10	31	30	27	401	78.8
Дунд	14	30	27	9	0	6	0	2	4	92	18.1
Хангалтгүй	2	5	6	3	0	0	0	0	0	16	3.1
2. Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээ хангалттай явагдаж байгаа эсэх?											
Сайн	50	104	84	45	12	12	31	30	27	395	78.7
Дунд	13	33	34	10	0	3	0	2	4	99	19.7
Хангалтгүй	1	3	2	1	0	1	0	0	0	8	1.6
3. Таны ажиллаж буй байр, давхарын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ хангалттай явагдаж байгаа эсэх?											
Сайн	34	89	71	38	12	13	31	30	24	342	66.2
Дунд	26	46	36	16	0	3	0	2	27	156	30.2
Хангалтгүй	4	3	11	1	0	0	0	0	0	19	3.7
Байр ашиглалтын чиглэлээр											
1. Таны ажиллаж буй байр, давхарын цахилгаан, ус, ариун цэврийн өрөөний хэвийн, найдвартай ажиллаж байгаа эсэх?											
Сайн		92	74	42	11	12				231	67.5
Дунд		41	34	10	1	1				87	25.4
Хангалтгүй		6	12	3	0	3				24	7
2. Цахилгаан, сантехник, мужаан, холбооны дуудлагын үйлчилгээ танд түргэн шуурхай хүрдэг эсэх?											
Сайн		85	70	42	9	11	31	21	20	289	66.4
Дунд		26	42	9	3	2	0	8	11	101	23.2
Хангалтгүй		11	7	0	0	1	0	3	0	22	5.1

Үйлчлүүлж байгаагүй		17	0	4	0	2	0	0	0	23	5.3
3. Хурлын заалны тоног төхөөрөмж шаардлага хангаж байна уу?											
Сайн		81								81	56.6
Дунд		32								32	22.4
Хангалтгүй		8								5	3.5
Үйлчлүүлж байгаагүй		18								25	17.5
Зоогийн үйлчилгээний чиглэлээр											
1. Зоогийн газрын хоолны нэр төрөл, амт чанар таны сэтгэлд нийцэж байгаа эсэх?											
Сайн	27	36								63	31.0
Дунд	29	64								93	45.8
Хангалтгүй	7	29								36	17.7
Үйлчлүүлж байгаагүй	0	11								11	5.4
2. Зоогийн газрын үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээнд сэтгэл хангалуун байдаг эсэх?											
Сайн	37	65								102	50.7
Дунд	19	52								71	35.3
Хангалтгүй	7	10								17	8.5
Үйлчлүүлж байгаагүй	0	11								11	5.5
Эмчийн үйлчилгээний чиглэлээр											
1. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээ чанартай хүрч чадаж байгаа эсэх?											
Сайн	45									45	70.3
Дунд	12									12	18.8
Хангалтгүй	0									0	0
Үйлчлүүлж байгаагүй	7									7	10.9
2. Их эмч, сувилагчийн харилцаа, үйлчилгээнд сэтгэл хангалуун байдаг уу?											
Сайн	47									47	73.4
Дунд	17									17	26.6
Хангалтгүй	0									0	0
Үйлчлүүлж байгаагүй	0									0	0

Шалгуур үзүүлэлтийн дагуу нэгтгэсэн дүн




Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээ /тоо/



- Сайн
- Дунд
- Хангалтгүй


График 1. Цэвэрлэгээ үйлчилгээний талаар санал асуулгын дүн

Байр, давхрын цахилгаан, ус ариун цэврийн өрөөний хэвийн найдвартай ажиллагаа /тоо/




- Сайн
- Дунд
- Хангалтгүй

Цахилгаан, сантехник, мужаан, холбооны дуудлагын үйлчилгээ /тоо/



- Сайн
- Дунд
- Хангалтгүй
- Үйлчлүүлж байгаагүй


Хурлын заалны тоног төхөөрөмж /тоо/



- Сайн
- Дунд
- Хангалтгүй
- Үйлчлүүлж байгаагүй


График 2. Байр ашиглалтын чиглэлээр санал асуулгын дүн

Зоог, цайны газрын хоолны нэр төрөл, амт чанар /тоо/



- Сайн
- Дунд
- Хангалтгүй
- Үйлчлүүлж байгаагүй

Зоог, цайны газрын үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээ /тоо/



- Сайн
- Дунд
- Хангалтгүй
- Үйлчлүүлж байгаагүй

График 3. Зоог, цайны газрын үйлчилгээний чиглэлээр санал асуулгын дүн



График 4. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэлээр санал асуулгын дүн

НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын харьцуулалт






График 5. Цэвэрлэгээ, үйлчилгээний чиглэлээр НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын а.х-ын өгсөн үнэлгээний харьцуулалт



График 6. Байр ашиглалтын чиглэлээр НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын а.х-ын өгсөн үнэлгээний харьцуулалт



График 7. Зоог, цайны газрын үйлчилгээний чиглэлээр НЗЗ-ны байрууд, НҮНТ-ийн салбаруудын албан хаагчдын өгсөн үнэлгээний харьцуулалт

Санал асуулгад ороцсон ажилтан, албан хаагчдаас гаргасан зарим санал, хүсэлт:

НЗЗ-ны 1-р байр:

- Өрөө тасалгааны цэвэрлэгээ, ариутгалыг сайжруулах,
- Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг сайжруулах, үнэр дарагч хэрэглэх,
- Ариун цэврийн өрөөнд саван, гарын цаасыг тогтмол хүртээмжтэй байлгах,
- Цайны газрын хоолны нэр төрөл, амт чанарыг сайжруулах,

НЗЗ-ны 2-р байр

- Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээг сайжруулах, /4, 5, 9, 10, 12 давхар/
- Зоогийн газрын үйл ажиллагаанд шинэчлэл хийх, ажилчдын харьцаанд анхаарах,
- Өглөөний цай гаргах,
- Хоолны нэр төрлийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах,

НЗЗ-ны 3-р байр

- Цахилгааны шугам, сүлжээний асуудлыг шийдвэрлэх,
- Өрөө тасалгааны цэвэрлэгээ, ариутгалыг сайжруулах,
- 00-ын өрөөний цэвэрлэгээ, үйлчилгээг сайжруулах, гар хатаагч шийдвэрлэх,

НЗЗ-ны 4-р байр

- Өвлийн улиралд ажлын өрөө, тасалгаа хүйтэн байдагийг шийдвэрлэх,

НЗЗ-ны 5-р байр Б корпус

- Байрны ард талын хогийн савны асуудлыг шийдвэрлэх,
- Ариун цэврийн өрөөг халуун устай болгох,

НЗЗ-ны 5-р байр В корпус

- Жижүүрүүдийн харилцаанд анхаарах,
- Ариун цэврийн өрөөнд гарын саван, цаас байлгах,

НҮНТ-ийн Драгон салбар

- Ариун цэврийн өрөөний үнэрийг арилгах,

НҮНТ-ийн Дүнжингарав салбар

- Мужаан, цахилгаанчин ойр ойрхон ирүүлж байх

Дүгнэлт

Тус сэтгэл ханамжийн судалгааг НЗЗ-ны байрууд болон НҮНТ-ийн салбаруудад ажиллаж байгаа 517 ажилтан, албан хаагчид оролцож санал хүсэлтээ өглөө. Санал асуулгыг НЗЗ-ны байруудад байрлаж байгаа ажилтан, албан хаагчдаас цахим хэлбэрээр, НҮНТ-ийн салбаруудад ажиллаж байгаа ажилтан, албан хаагчдаас цаасаар авч дүнг нэгтгэсэн.

1. Өрөө тасалгааны цэвэрлэгээ үйлчилгээнд сайн үнэлгээ өгсөн 401, дунд 92, хангалтгүй 16 үнэлгээг тус тус өгсөн байгаа нь цэвэрлэгээ үйлчилгээнд сэтгэл хангалуун байгааг харуулж байна. Байруудын харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 5-р байрны Б корпус, НҮНТ-ийн Мишээл салбарт ажиллаж байгаа албан хаагчид хамгийн сэтгэл хангалуун байсан ба 5-р байрны В корпусын өрөө тасалгааны цэвэрлэгээнд илүү анхаарах шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

2. Нийтийн эзэмшлийн талбайн цэвэрлэгээ, үйлчилгээнд сайн үнэлгээ өгсөн 395, дунд 99, хангалтгүй 8 үнэлгээг тус тус өгсөн байна. Харин НЗЗ-ны байрууд, НҮНТ-үүдийн санал өгсөн байдлыг харьцуулж харахад НЗЗ-ны 1, 2, 3, 5-р байрны В корпусын цэвэрлэгээнд илүү анхаарах шаардлагатай байна.

3. Ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээний талаарх асуулгад сайн 342, дунд 156, хангалтгүй 19 үнэлгээг өгсөн. Харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 1, 3 дугаар байруудын ариун цэврийн өрөөний цэвэрлэгээ үйлчилгээнд анхаарах шаардлагатай байна.

4. Инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд сайн 231, дунд 87, хангалтгүй 23 үнэлгээг өгсөн байна. Харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 3-р байрны инженерийн шугам сүлжээний хэвийн ажиллагаанд бусдаасаа доогуур үнэлгээ өгсөн байна.

5. Дуудлагын үйлчилгээний талаарх асуулгад сайн 289, дунд 101, хангалтгүй 22, үйлчлүүлж байгаагүй 23 гэсэн үнэлгээг тус тус өгсөн. Харьцуулсан графикаас харахад НЗЗ-ны 2, 3 дугаар байруудын дуудлагын үйлчилгээнд анхаарах шаардлагатай байгаа нь харагдаж байна.

6. Зоогийн газрын үйл ажиллагаанд НЗЗ-ны 1, 2 дугаар байрны ажилтан, албан хаагчид санал өгсөн бөгөөд хоолны нэр төрөл, амт чанарт сайн 63, дунд 93, хангалтгүй 36, үйлчлүүлж байгаагүй 11 гэсэн үнэлгээг тус тус өгсөн байгаа нь хоолны амт чанарт сэтгэл дундуур байна.

7. Зоогийн газрын үйлчилгээний ажилтны харилцаа, үйлчилгээний талаарх асуултанд сайн 102, дунд 71, хангалтгүй 17, үйлчлүүлж байгаагүй 11 гэсэн үнэлгээг тус тус өгсөн байгаа нь ажилтнуудын харилцаанд дийлэнх нь сэтгэл хангалуун байгааг боловч цаашид энэ үнэлгээг ахиулах шаардлагатай байна.

8. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд НЗЗ-ны 1-р байрны ажилтан, албан хаагчид санал өгсөн ба сайн 45, дунд 12, үйлчлүүлж байгаагүй 7 гэсэн үнэлгээ өгсөн байна.

9. Их эмч, сувилагчийн харилцаанд дийлэнх нь сайн үнэлгээ өглөө.

10. Цэвэрлэгээ, үйлчилгээнд өгсөн дундаж үнэлгээ /тоогоор/




График 8. Цэвэрлэгээ, үйлчилгээнд өгсөн үнэлгээ

11. Байр ашиглалтын чиглэлээр өгсөн дундаж үнэлгээ /тоогоор/




График 9. Байр ашиглалтын чиглэлээр өгсөн үнэлгээ

12. Зоогийн үйлчилгээний чиглэлээр өгсөн дундаж үнэлгээ /тоогоор/




График 10. Зоогийн үйлчилгээний чиглэлээр өгсөн үнэлгээ

13. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэлээр өгсөн дундаж үнэлгээ /тоогоор/




График 11. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээний чиглэлээр өгсөн үнэлгээ

14. Байгууллагын үйл ажиллагаанд өгсөн нэгдсэн дүн /хувиар/




График 12. Байгууллагын үйл ажиллагаанд өгсөн үнэлгээ

Нэгдсэн дүнгээс харахад манай байгууллагын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хэрэгжилтийг дийлэнх хэсэг нь сайн гэж үнэлсэн бөгөөд цаашид дунд, хангалтгүй үнэлгээг бууруулахад анхаарч, төрийн албан хаагчдаас гаргасан санал, гомдлыг судлан үзэж, шийдвэрлэн ажиллах болно.

ТАНИЛЦСАН:

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Х.ЭРДЭНЭБИЛЭГ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ч.ШИНЭЧИМЭГ

ИЛТГЭХ ХУУДАС БИЧСЭН:
ДОТООД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ
ҮНЭЛГЭЭНИЙ АЖИЛТАН

Т.ИТГЭЛ

ИЛТГЭХ ХУУДАС ХҮЛЭЭН АВСАН:

БАЙР АШИГЛАЛТЫН АЛБАНЫ ДАРГА

Г.БАТЗАЯА

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ ДАРГА

М.АЛТАНТУЯА